



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар A/1632.

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн “Баянзүрх эко тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт болон 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргээдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.”Улаанбаатар хотын хүнсний хог хаягдал дахин боловсруулах төсөл”-ийн хөрөнгөөр нийлүүлсэн нийт 138,105,000.0 (нэг зуун гучин найман сая нэг зуун таван мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Баянзүрх дүүргийн “Баянзүрх эко тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ (Д.Өлзийдэмбэрэл)-т зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн “Баянзүрх эко тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ (Д.Өлзийдэмбэрэл)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
B.ОЮУМАА





Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
дартын 2024 оны 12 дугаар сарын 18-ны
өдрийн А/Д дугаар тушаалын жаворлалт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд буртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Баянзүрх эко тохиижилт үйлчилгээ ОНӨААТУГ

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	ABCASH OH ALUMINUMSTAA Thaap GanZtar	Хамжих ёлж TOO Xemjaa	Бүртгэлд авах		Эх үүсвэр
					Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1	Навч, хаягдал сорох машин	MAMUT PRO BT	2024	Шинэ 3	46,035,000.0	138,105,000.0	Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл
Нийт буртгэх хөрөнгийн дун							138,105,000.0